

**САНАА БИЧИГ СУДЛАЛД****Д. Жамсранжав**

Аливаа ард түмний соёлын дурсгалд бичгийн тухай асуудал гол суурийг нь эзлэх бөгөөд монголчууд бидний өвөг дээдэс маань дэлхийн бусад улс түмэн лугаа нэгэн адил бичиг зохиол хэрэглэж ирсэн түүхтэй, авианы бичиг үүсэхийн өмнөх үед ч хүн төрөлхтний хэрэглэж ирсэн санаа бичиг (фразография) хэрэглэж байсан нь монгол нутагт буй чулуун дээрх зураг, овгийн тамга, эд агуурсын хээ хуар, археологийн олдвор, аман зохиол, домог яриа зэрэгт ул мөрөө үлдээжээ. Цагаан толгойт, авианы бичигтэй болсноос хойш ч гэсэн «гурван хэлхээ таван үүрд»<sup>1</sup> гэвэл далд утгаараа хаан эзэн, харц олонтойгоо; эцэг нь хүүтэйгээ, эр нөхөр нь эхнэртэйгээ бат холбоотой байх буюу өршөөл, журам, ёслол, мэргэн, бат байх, хүний эрхэмлэж явбал зохих ёс суртахууны таван чанарыг өгүүлэх мэтээр ёгт билиг ч хэрэглэж байжээ.

Монголчууд эх газрын биеэ аж амьдралтай ард түмэн байсан болохоор, бидний өвөг дээдэс төв азийн нүүдэлчин монголчууд тухайн үеийнхээ тэргүүн орны соёлыг тусган, байгаль, ан амьтан, ургамал, эд агуурсын дүрс бүхий өөрийн өвөрмөц санаа бичгийн дурсгалыг үлдээсэн нь мэдээж бөгөөд зарим эрдэмтэн «зураг бичгээс өмнөх»<sup>2</sup> гэж үздэг. Жишээлэхэд «адил, тэгш» гэсэн утга бүхий «зуузай» буюу «дэгрээ» тамга эртний дорно, өрнө дахины бичиг үсгийн дүрсэнд байх ба евразийн өргөн дэлгэр нутаг, Алтай, Өмнөд Сибирь, Туваа болон монголын овгийн, малын тамга, археологийн олдвор, хээ хуар зэрэгт элдэв хэлбэрээр элбэг тохиолддог билээ.

Хүн төрөлхтөн анх авианы бичгийг зохиоходоо үсэг тус бүрийг бодит нэг юм дууриалган бичилбэрээ бүтээснийг «Шугам, гадаргуу, өнцөг, олон өнцөгт, шоо дөрвөлжин, бөмбөлөг гэх мэтийн тухай төсөөллүүд цөм л бодит юмнаас хийсвэрлэсэн»<sup>3</sup> гэж Ф. Энгельс, «Дюрингийн эсрэг» зохиолдоо бичжээ.

Харин, санаа бичиг бол ганц нэг буюу, хэдэн дүрс зураг, хээ хуар төдийхнөөр өргөн дэлгэр утга санаа гаргадаг бөгөөд Онон, Хэрлэн, Туул, Орхон, Сэлэнгэ голын хавьцаа нутаглаж байсан монгол угсаатнуудын хэрэглэж байсан санаа бичгийн зүйлийг судлахад дээр дурдсанаас гадна «Монгол бичгийн системтэй гэж судлагдсан»<sup>4</sup> Х зуунд холбогдох хятан бичиг онц холбогдолтой ажээ.

Санаа бичиг олон үе улиран дамжсан, эхин нь овгийн байгууллын үед холбогдох учир тэр үеийн хүний ажил төрөл, утга соёл, зан заншлыг сайн мэдэхгүйгээр зөв ойлгох бололцоогүй, үүнийг үнэн зөв тодорхойлох нь ард түмний түүх, угсаа гарлыг үнэн зөв гаргахад гол нэг зүйл нь болдог. Жишээ нь ан амьтныг дүрслэх скиф маяг аргалийн эврийн дүрсээс сэдэвлэсэн угалзыг төв Азийн нүүдэлчид бүтээсэн нь маргаангүй бөгөөд хээ угалз бүхэн гүн гүнзгий утга агуулга хадгалж байдгийг санаа бичиг гэж болох бүрэн үндэстэй байна.

Ийм учир «хаданд байгаа... улаан будагт зургууд нь зөвхөн чимэглэл хээ угалзын зүйл биш, харин хүмүүсийн ямар нэгэн санааг дамжуулан илэрхийсэн тэмдэг болох нь дамжиггүй боловч чухам юу гэснийг судлан тайлбарлах нь чухал байна»<sup>5</sup> гэж Өвөрхангай аймгийн Шурангийн бичигт улаан хадны зургийн тухай түүхчид бичдэг ажээ.

Энд монгол нутгаас олдсон хятан үсэг гэж үзвэл зохих (Х. Пэрлээ «Чин толгойн балгасны бичигт ваар», УБ., 1959, 4 дэх тал) гурван үсгийн тухай нягтлан, энэ үсэгтэй нэг гаралтай хэдэн бичээс дурдан, санаа бичгийн зүйлд холбогдолтой гэж бичсүгэй.

1. Франклин Фолсом. «Книга о языке» («Прогресс» Москва-1974. стр. 59) номд буй» Хятад<sup>6</sup> сийлбэрийн зургаан иероглифийг үзвэл 3-5 дахь (3 үсэг) нь дээрх гурван дүрсийн бага зэрэг өөрчлөгдсөн адил үсэг болох нь илэрхийн дээр Ф. Фолсомын номын бүдүүвчид харвал, буй газрыг нь Шар мөрний эх хавь руу зурсан нь бидний анхаарлыг татаж байна.

2. «Наука и жизнь» (1978 он, №4, 59 дэх тал) сэтгүүлд доктор профессор Н. Мерперийн бичсэн өгүүллийн дөрвөн иероглиф өмнөх зургаан үсгийн дундах 4 үсэгтэй адил байх ба сүүлчийн гурав нь дээрхтэй адил байна. Энэ хоёр бичээсийн буй зүйл нь өөр өөр байгаа нь бас сонирхуштай.

3. Таван цэн орчим цагаан мөнгөн зоос дээр буй дүрсийг дээр дурдсан ваар дээрх гурван үсгийн эцсийнхийг бага зэрэг өөрчлөгджээ гэж үзэж болох үндэс бас байна. Ийнхүү дээрх гурван үсгийг дурдаж буй бичээстэй харьцуулбал:

— Дурдсан бичээсүүдэд төстэй хэлбэрээр гурав дахин тохиолдох ба иймэрхүү дүрсээр эртний Египедэд шувууг дүрсэлж байсан хийгээд, Монголд малын тамга, Мөнх хааны зоос дээр, Мөрт цагаан чулууны хадан дээрх бичиг зэрэгт байх ба хуучин германы болон скандиновын руни «бичиг», Болгарын археологийн тамга, Унгарын овгийн ба өрх (мал)-ийн тамга, «Нангиадын гадаад аймаг аде. эдиз овог»<sup>7</sup> гэх мэтээр адилавар дүрс үзэгдэх ба Чин толгойн ваар дээрхийг «мод» гэсэн нанхиад мод гэсэн эвхмэл үсэг гэж Х. Пэрлээ<sup>8</sup> бичжээ. Түүнчлэн, монголчууд «ланз» хэмээн «баяр үсэг» гэсэн утгатай гэлцдэгийг ч бодсон, нисэж яваа шувуун дүрсээрээ сайн сайхныг бэлэгдсэн эртний санаа бичиг гэлтэй.

-- Дурдсан бичээсүүдэд адил буюу бага зэрэг өөрчлөгдсөн хэлбэрээр хоёр дахин тохиолдох ба дорнодахины дурсгалуудад үзвэл дөрвөн зүг найман зовхисыг заасан дүрсээрээ «хаан, эзэн»<sup>9</sup> гэсэн утгатай санаа бичиг гэж үзэж болох үндэслэл байна.

— Дурдсан бичээсүүдэд ойролцоо буюу бага зэрэг өөрчлөгдсөн, савтай гурван юмын хэлбэрээр гурав дахин тохиолдож байгааг үзвэл төв азийнхан хэн нэгэн нь, бие биеэс санаа авч, дам дам, олон үед хэрэглэсэн бөгөөд мөнгөн дээрх дүрсийг «Киданд 907 - 1125 онд удаа дараа 30 гаруй төрлийн зоос цутган гаргажээ...Киданы үед «Бао» гэсэн үгийг зэргэлдээ оршиж байсан хятад орноос...«эрдэнэ» гэсэн утгаар нь зээлдэн авч хэрэглэсэн байж болох юм»<sup>10</sup> Гэтэл Бао («Эрдэнэ») гэсэн үгийг хятад дүрс бичиг ба хадаг, зоос, хүний нэр зэрэгт байх манж үсгийн дуудлага нь хятадтай ойролцоо, үсэг нь хятад биш учир «Эрдэнэ» гэсэн санаа бичиг байж магад гэсэн санаа төрүүлж байна.

Эд бүхнээс үзвэл тэр ваар дээр буй гурван үсэг, нэгийг олон дахин бичсэн учир туйпуучны нэр биш

- эрдэм ухаан дэлгэрэх болтугай
- эзэн төр амгалан байх болтугай
- эд агуурс арвидан дэлгэртүгэй

гэсэн санаа бичиг байна гэсэн бодол төрүүлэв. Санаа бичиг олон үеийн монгол угсаатанд хэрэглэгдсээр ирсэн «буга, янгир, нар, сар, угалз, туур буюу онги, чандмань, зуузай, алх» гэх мэт дүрс нь өргөн утга санаа илэрхийлсэн, өнө эртний гаралтай төв азийн ард түмний

бүтээл, зураг болон цагаан толгойт авианы бичигт хүртэл ул мөрөө үлдээсэн, нэг талаас нь хараад шууд тайлбарлахад бэрх, нарийвчлан судлууштай, учир нь олдох зүйл болох нь илэрхий байна гэсэн дүгнэлт гарч ирж байна.

<sup>1</sup> Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. УБ., 1928, 65 дахь тал

<sup>2</sup> Б. А. Истрин. Возникновение и развитие письма. М., 1965. , стр. 38-д үз

<sup>3</sup> Ф. Энгельс. Дюрингийн эсрэг, УБ., 1979, 43 дахь тал

<sup>4</sup> «Материалы по дешифровке киданского письма. I—II» (Москва, 1970)

<sup>5</sup> «Шинжлэх ухаан техник» УБ., 1957. 21 дэх тал

<sup>6</sup> О. Жамъян. «Урд өдрийн олиг үгийн бичиг» номдоо хятанг хятад гэж бичсэн нийг үзвэл хятан сийлбэр байж магадгүй. 205 дахь тал

<sup>7</sup> Х. Пэрлээ Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь» УБ., 1976, 205 дахь тал

<sup>8</sup> Х. Пэрлээ. Чинтолгойн бичигт ваар. УБ., 1959, 4 дэх тал

<sup>9</sup> А. А. Серкина. Опыт дешифровки древнейшего китайского письма «Наука», М., 1973, с.116-д үзмүү

<sup>10</sup> «Шинжлэх ухаан амьдрал» УБ., 1970, 16 дахь тал

**ХЯТАД ХЭЛНИЙ  
МЭНДЛЭХ ЗОЛГОХ, САЛЖ  
ХАГАЦАХ ЗАРИМ ҮГ  
ХЭЛЛЭГИЙН ТУХАЙ**

**Я. Ганбаатар**

Сүүлийн жилүүдэд БНХАУ дэлхийн тавцан дээр дахин гарч ирж өөрийн гэсэн байр сууриа эзэлсэн нь дэлхий дахинаа эртний түүх соёлтой энэ орныг сонирхон судлах хүсэл эрмэлзлийг зүй ёсоор хүчтэй сэргээсэн билээ. Үүний үрээр хятад судлалын ажил үйлс ихээхэн эрчимтэй явагдах боллоо. Сүүлийн үед манай оронд ч хятад судлал нэлээд идэвхжиж байна.

Хятад хэл бол олон мянган жилийн туршид бие даасан хэл-соёл болон хөгжиж ирсэн эртний баялаг хэлнүүдийн нэг юм. Тийм ч учраас гадаад дотоодын олон эрдэмтэн судлаачийн онцгой анхааран судалж буй нэг талбар болж байгаа нь маргаангүй. Харин манай улсад хятад хэл бичиг, уран зохиолыг тусгайлан судалж буй ажил хараахан эрчимтэй бус буюу ер нь хийсэн зүйл үгүй гэж хэлж болмоор байна. Иймд манай хятад судлаач эрдэмтэн мэргэд нэн ялангуяа шинэ залуу мэргэжилтнүүд энэ чиглэлээр судалж шинжлэх нөр их ажлыг эхлэх цаг болжээ. Энэ удаад хятад хэлний мэндлэх золгох, салж хагацахдаа хэлдэг, хэлцдэг үг хэллэгийн заримаас товч авч үзье. Энэхүү бяцхан өгүүлэлд нийт хятад хэлэндэх мэндлэх золгох, салж хагацах үг хэллэгийг бүгдийг цуглуулан жагсаах зорилт тавиагүй бөгөөд, зөвхөн өвөрмөц онцлог шинж бүхий тодорхой цөөн хэдэн үг хэллэгийг үндэсний зан заншил, угсаатны ёс зүйтэй нь холбон авч үзэж, тайлбарлахыг хичээлээ. Ер нь хятад хэлний дээрх төрлийн үг хэллэг үндэсний нэлээд өвөрмөц онцлогийг хадгалсан байдгийн зэ-